



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 118

Баянхутаг сум

АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэн хийгдсэн тавилга эд хогшил болон сандал ширээ хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Наранбадрал – Засаг даргын орлогч

Гишүүд: О.Цэрэннадмид – Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Д.Алтанчимэг – 2-р багийн засаг дарга

Л.Мөнхцогт – Соёлын төвийн хөгжмийн багш

Ц.Цэрэннадмид – Соёлын төвийн өвийн ажилтан.

2. Тус хөрөнгийн үзүүлэлтийг тодорхойлолтод заасны дагуу гүйцэтгэсэн эсэхэд хяналт тавин хүлээж авахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3. Ажил хүлээлцсэн акт, гүйцэтгэлийн тайлан зэрэг холбогдох бусад бичиг баримтыг үндэслэн тус тавилга эд хогшил болон сандал ширээ төслийн санхүүжилтийг олгохыг нягтлан бодогч (Х.Энхцэцэг)-т үүрэг болгосугай.

4. Соёлын төвд хүлээн авсан үндсэн хөрөнгөд бүртгэж авахыг нягтлан бодогч (Х.Энхцэцэг), Няраб (Ц.Цэрэннадмид) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЙГАЛМАА



232501078